



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар АБ18

Булган сум

Ээлжит цэрэг татлага явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах хэсэг, Засгийн газрын 2025 оны мн/148 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2026 оны мн/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагын урьдчилсан үзлэгийг сумдад 2026 оны 04 дүгээр сарын 17-25-ны хооронд, нэгдсэн үзлэгийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Булган суманд төвлөрүүлэн зохион байгуулж, Орхон, Бүрэгхангай, Дашинчилэн, Баяннуур, Рашаант, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр сумдыг хамруулсугай.

2.Цэрэг татлагын товчоог 1 дүгээр, эмч нарын комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар, цэрэг татлагын эрүүл мэндийн урьдчилсан үзлэг явуулах хуваарийг 3 дугаар, зарцуулах хөрөнгийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталж, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг хуваарийн дагуу явуулах, цэрэг татлагын ажлыг сайтар зохион байгуулахыг Цэрэг татлагын товчоо (Д.Эрдэнэбилэг), Цэргийн штаб (Дэд хурандаа Т.Нямхүү), эмч нарын комисс (Б.Шижирбаатар)-т тус тус хариуцуулсугай.

3.2026 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагад зарцуулах 16,072,000 (арван зургаан сая далан хоёр мянга) төгрөгийг Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

4.Сумын Эрүүл мэндийн төв, Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж мансууруулах бодисын хамааралтай, энэ төрлийн эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, тэдгээрийн түүхий эдийг хэрэглэдэг, мансуурах донтой иргэдийн судалгаа, Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж өвчилж болзошгүй болон сүрьеэгийн ойрын хавьталтай цэргийн насны залуучуудын судалгааг тус тус гаргаж, цэрэг татлагаас өмнө сүрьеэгийн сорил тавих ажлыг зохион байгуулан ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт даалгасугай.

6326010293

Sugar Ажил 2026 өдөр бүр Doc/2026/Захирамж

5.Эмнэлгийн үзлэгт орох залуучуудын шинжилгээг Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 1, 6, 7 дугаар зүйлийг үндэслэн зохион байгуулахыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нарантуяа), Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга (П.Оюунцэцэг) нарт тус тус хариуцуулсугай.

6.Цэрэг татлагын товчоо, эмч нарын комисс сумдад ажиллах, хугацаат цэргийн албанд татагдаж буй иргэнийг тээвэрлэх арга хэмжээг зохион байгуулахдаа хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөж, авто техникийн бүрэн бүтэн байдлыг сайтар хангах, хамрагдвал зохих хүмүүсийг бүрэн хамруулан аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хяналтын тоог биелүүлж, цэрэг татлагын ажлыг хугацаанд нь зохион байгуулж, дүнг 2026 оны 05 дугаар сарын 15-ны дотор илтгэхийг Цэрэг татлагын товчоо (Д.Эрдэнэбилэг), Цэргийн штаб (Дэд хурандаа Т.Нямхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 30-ны/ний өдрийн
Х/Б/18 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



2026 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧОО

Цэрэг татлагын товчооны
дарга:

Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын дарга)

Цэрэг татлагын товчооны
нарийн бичгийн дарга:

Т.Нямхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Цэргийн штабын дарга, Дэд хурандаа)

Цэрэг татлагын товчооны
Гишүүд:

Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга,
Цагдаагийн хурандаа)

Н.Хишигдорж (Онцгой байдлын газрын дарга,
Дэд хурандаа)

Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Шижирбаатар (Нэгдсэн эмнэлгийн захирал)

Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)

Б.Жавзмаа (Рашаант сумын Засаг дарга)

Г.Энхбат (Могод сумын Засаг дарга)

С.Батнасан (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга)


П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн даатгалын
хэлтсийн дарга)

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)

Б.Намнансүрэн (Цэргийн штабын Орон нутгийн
хамгаалалт, сургалтын офицер, Дэд хурандаа)

Ц.Цэрэнтогтох (Цэргийн штабын дайчилгааны
офицер, Хошууч)

А/218 03 Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 20-ныгний өдрийн
03 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Эмч нарын комиссын бүрэлдэхүүн

- | | |
|----------------------------------|---|
| 1. Ерөнхий эмч | Б.Шижирбаатар (Нэгдсэн эмнэлгийн захирал) |
| 2. Дотрын эмч | Б.Энхмөнх |
| 3. Мэс заслын эмч | М.Билгүүн |
| 4. Чих, хамар хоолойн эмч | Б.Сүхдорж |
| 5. Мэдрэлийн эмч | Д.Гүндэгмаа |
| 6. Сэтгэцийн эмч | Н.Уянга |
| 7. Нүдний эмч | М.Давхарбаяр (Амбулаторийн эрхлэгч) |
| 8. Арьс өнгөний эмч | Ч.Амаржаргал |
| 9. Сүрьеэгийн эмч | Г.Цэрэнлхам |
| 10. Шүдний эмч | Б.Бат-Ундраа |
| 11. Дүрс оношлогооны эмч | М.Энхцэцэг |
| 12. Рентген техникч | Ж.Түвшинсанаа |
| 13. Оношилгооны тасгийн лаборант | Д.Ганганцэцэг |

А. 218 03 Аймгийн Засаг даргын 2026 оны
03 дугаар сарын 30 ны/ний өдрийн
03 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт




СУМДАД ЦЭРЭГ ТАТЛАГЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛСАН ҮЗЛЭГ
ЯВУУЛАХ ХУВААРЬ

д/д	Сумын нэр	Урьдчилсан үзлэг явуулах хугацаа	Үзлэгт орох хүний тоо	Цэргийн жинхэнэ албанд татах хүний тоо
1	2	3	4	5
1	Орхон	04-р сарын 17	138	22
2	Бүрэгхангай	04-р сарын 18	96	14
3	Дашинчилэн	04-р сарын 19	110	18
4	Баяннуур	04-р сарын 20	58	12
5	Рашаант	04-р сарын 21	86	18
6	Гурванбулаг	04-р сарын 22	102	22
7	Могод	04-р сарын 23	93	18
8	Хишиг-Өндөр	04-р сарын 24	105	18
9	Булган	04-р сарын 25	406	30
10	Нэгдсэн эмнэлэгт шинжилгээ өгөх	04-р сарын 29-30		
11	Аймгийн нэгдсэн үзлэг	05-р сарын 01		
12	Анги байгууллага руу үдэн гаргах	05-р сарын 02		
Бүгд			1194	172

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
03. дугаар сарын 30-ны/ний өдрийн
Х/Б/18. дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт



2026 ОНЫ НЭГДҮГЭЭР ЭЭЛЖИЙН ЦЭРЭГ ТАТЛАГАД
ЗАРЦУУЛАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын чиглэл	Хөрөнгийн хэмжээ /төг/	Тайлбар
1	2	3	4
1	Цэрэг татлагын товчоо, сумаас цэрэг хүргэж ирсэн хүмүүс, Цэргийн ангиас цэрэг хүргэж ирсэн офицерууд, ЦТБ дээр ажиллах хүмүүсийг хооллох, байрлуулах	10,740,000	68 хүн 1 өдөрт 35000 төг 3 өдөр хооллоно. Байр-20*3*60000=3600000
2	Цэргийн албанд татагдсан залуучуудыг цэргийн анги байгууллагад хүргэх замд 1 удаа хооллоход	1,100,000	110 хүн 1 удаа (1 хүн 10000 төгрөгөөр хооллоно)
3	Суманд цэрэг татлагын урьдчилсан үзлэг явуулах, УБ хот руу цэрэг хүргэж өгөх унааны зардал /шатахуун/	1,632,000	АИ-92 600л*2720
4	Суманд ажиллах эмч нарын томилолтын зардалд	1,620,000	6 эмч 9 хоног*30000
5	Бусад зардалд	980,000	Цэвэр ус, нойтон сальетка, гар ариутгагч, маск гэх мэт
Бүгд			16,072,000

--o00o--